

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

1. **“Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/** 3-4

2. **“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/** 4-4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 10-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл-/**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 53 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар,
Ш.Раднаасэд, Б.Чойжилсүрэн;

Томилолттой: Д.Өнөрболор.

Нэг. “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн Редакц, кодификацийн албаны ахлах зөвлөх Б.Батчимэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн Редакц, кодификацийн албаны ахлах зөвлөх Б.Батчимэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Л.Энх-Амгалан, Ч.Хүрэлбаатар нарын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах ажлыг” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 10 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 17 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 16 цаг 53 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ дахиад өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Нийт хуралдаанд оролцох 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Булгантуяа гишүүн, Одонтуяа гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Баделхан гишүүн, Даваасүрэн гишүүн, Хүрэлбаатар гишүүн, Батжаргал гишүүн, Жавхлан гишүүн, Сандаг-Очир гишүүн гээд нийт 12 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Ингээд Байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааныг дахин нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 2 тогтоол байгаа. Та бүхэнд танилцуулъя.

1.Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн хэлэлцүүлэг байгаа.

2.Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын анхны хэлэлцүүлэг байгаа.

Ийм 2 асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Алга байна. Саяны танилцуулсан тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэг гээд ийм 2 асуудалтай байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу. Алга байна.

1 дэх асуудлаа хэлэлцэж эхэлбэ.

“Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39¹.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.5 дах хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журам”-ын дагуу ирүүлсэн PN-202310-70621 дугаартай нийтийн өргөдөл, PN-202310-96904 дугаартай нийтийн өргөдлийн үр дүнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын нэмэгдсэн өртгийн албан татвар болон татварын орчинд үнэлэлт, дүн шинжилгээ хийж шударга ёсны зарчимд нийцүүлэн татварын орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд даалгасугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан асуудлаар шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан нар танилцуулъя.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм 3 заалттай тогтоол байна.

Ингээд тогтоолын төслийг уншиж танилцууллаа. Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн миний бие нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Ингээд тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцүүлж дууслаа.

17.00 цаг.

Хоёр дахь асуудал. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Анхны хэлэлцүүлэг байна.

Та бүхэнд Төсвийн байнгын хорооноос боловсруулсан тогтоолын төслийг тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Тогтохсүрэн гишүүн байна. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ тогтоолын төслийг өмнө нь Байнгын хороо анхны хэлэлцүүлэг хийсэн. Өнөөдөр чуулганаар анхны хэлэлцүүлэг хийгдэхийн өмнөхөн тус зарчмын зөрүүтэй зайлшгүй шаардлагатай санал байсан. Тийм учраас хүсэлт гаргаад, хурал даргалагчаас энэ тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэг дахиж хийлгэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээн, тэрний дагуу анхны хэлэлцүүлэг хийгдэж байгаа юм. Тийм учраас өмнө гарсан саналуудыг дэмжээд, нэмж нэг санал хэлье. Здах

санал болгож. Та бүхэнд тараагдсан болов уу гэж бодож байна.

Төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах ажлыг” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Л.Энх-Амгалан, Ч.Хүрэлбаатар гэсэн ийм санал байна. Дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн гишүүнд баярлалаа. Ингээд Тогтохсүрэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтад 8 гишүүн оролцож 66.7 хувиар дэмжигдлээ. Ингээд 8 гишүүн дэмжлээ.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Ингээд тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаан дууссаныг та бүхэнд мэдэгдье. Баярлалаа.

17.03 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ